



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 03 сарын 21 өдөр

Дугаар 110

Улаанбаатар хот

### Удирдамж болгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг, 21 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 65 дугаар зүйл, 79 зүйлийн 79.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Булган АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдэд дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг удирдамж болгосугай.

1.1.“Булган АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Э.Пүрэвдэмбэрэл нь үүрэгт ажлаас чөлөөлөгдөх хүсэлт өгсөн тул үүрэгт ажлаас чөлөөлж, түүнтэй байгуулсан Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээг 2024 оны 03 дугаар сарын 21-ний өдрөөс тасалбар болгон холбогдох хууль тогтоомжийн дагуу цуцлах;

1.2.“Булган АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгчээр ерөнхий инженер М.Мөнх-Эрдэмийг холбогдох хууль тогтоомжийн дагуу томилж, Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах.

2.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Ц.БАЯР-ЭРДЭНЭ